



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: za@zavkhan.gov.mn

2025. 05.01 № 3/488
танай _____ -ны № _____ т

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАРГА,
ЗАХИРАЛ, ЭРХЛЭГЧ, СУМЫН
ЗАСАГ ДАРГА НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан "Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, орон сууцны дэмжлэг үзүүлэх" арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлыг төлөвлөж байна.

Төрийн албан хаагчдыг орон байраар хангахад орон нутгаас дэмжлэг үзүүлэх, сонгон шалгаруулах ажлын хэсгийн удирдамжийг хүргүүлж байна.

Тус ажлын хүрээнд журмын дагуу төрийн албан хаагчийн шаардлага хангасан материалыг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн дотор ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Чадраабал)-т ирүүлнэ үү.

Жич: Боловсрол, эрүүл мэндийн салбарын хувьд аймгийн харьяа агентлагтаа шаардлага хангасан албан хаагчдын материалыг хүргүүлэхийг мэдэгдье.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГА



Т.РЭНЧИНВАНЖИЛ

8109080116

БАТЛАВ.
ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА *Г.З.ОТ.РЭНЧИНВАНЖИЛ*

2025 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ ОРОН БАЙРААР ХАНГАХАД
ОРОН НУТГААС ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төрийн албан хаагчдад орон байрны дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж, мөрдлөг болгоно.

1.2.Төрийн албан хаагчдад орон байрны дэмжлэг үзүүлэхдээ шударга, ил тод, нээлттэй байдлыг хангах, ажлын үр дүнг бодитой үндэслэх, хамт олны оролцоог хангасан байх зарчмыг баримтална.

ХОЁР. ЗОРИЛГО

2.1.Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг баталгааг хангах, төрийн албан хаагчдад орон байрны дэмжлэг үзүүлэх замаар чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, боломжийг бий болгоход оршино.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

3.1.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн албаны тухай хуулийн 3.1.2 дахь хэсэгт хамрагдах төрийн албан хаагчид

**ДӨРӨВ. ОРОН БАЙРНЫ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

4.1.Сонгон шалгаруулалтыг хоёр үе шаттайгаар зохион байгуулна.

4.1.1.Нэгдүгээр үе шат – Байгууллагууд хамт олны дийлэнх олонхийн саналаар шалгарсан төрийн албан хаагчийн материалыг ажлын хэсэгт ирүүлнэ. Боловсрол, эрүүл мэндийн салбарын хувьд аймгийн харьяа агентлаг нь шаардлага хангасан материалыг хянаж эрэмбэлэн ирүүлнэ.

4.1.2.Хоёрдугаар үе шат – Ажлын хэсэг байгууллагуудад тавигдах шаардлага, төрийн албан хаагчид тавьсан шалгуур үзүүлэлт хангасан эсэхийг хянан шийдвэрлэнэ.

4.2.Ажлын хэсгийн гишүүд ашиг сонирхлын зөрчилгүйгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тохиолдолд мэдэгдэл гаргана.

4.3.Олон улс, улсын хэмжээнд онцгой амжилт гаргасан төрийн албан хаагч болон шавийн амжилтыг бодлогоор дэмжиж, орон байрны дэмжлэгт хамруулж болно.

4.4.Төрийн албан хаагчдын амьдралын зайлшгүй нөхцөл байдал, хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг харгалзан орон байраар хангахтай холбоотой дэмжлэгт хамруулж болно.

4.5.Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд нийслэл хотоос орон нутагт шилжин суурьшиж буй төрийн албан хаагчийн амьдрах боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлж болно.

4.6.Тухайн жилийн шилдгээр шалгарсан сум, агентлаг тус бүрээс 1 төрийн албан хаагчийг ажлын хэсэг шалгаруулж, орон байрны дэмжлэгт хамруулж болно.

4.7.Орон байрны дэмжлэгийг орон нутагтаа байр барих болон худалдан авахад зориулж урьдчилгаа төлбөрт, эсхүл зээлийн данс руу шилжүүлэх бодлого баримтална.

ТАВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

5.1.Орон сууцны дэмжлэгт төрийн албан хаагчдаа хамруулах төрийн байгууллагад дараах шаардлагыг тавина.

5.1.1.Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг байгууллагын зүгээс санаачилсан байх;

5.1.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад хангасан байх;

5.1.3.Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулсан байх; (Эрүүл мэндийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 23-ний өдрийн А/472 тушаалаар батлагдсан журам)

5.1.4.Нийтийн биеийн тамирыг дэмжих чиглэлээр зохион байгуулагдаж буй арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцсон байх;

5.1.5.Тохижилт үйлчилгээ, ногоон байгууламж, бүтээн байгуулалтын ажил санаачлан хийсэн байх;

5.1.6.Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнг харгалзан үзнэ.

5.2.Орон байрны дэмжлэгт хамрагдах төрийн албан хаагчид дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

5.2.1.Төрийн албанд 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан байх;

5.2.2.Сүүлийн 3 жилд “хангалттай” үнэлэгдсэн байх;

5.2.3.Сүүлийн 1 жилийн хугацаанд ёс зүйн болон сахилгын хариуцлага хүлээгээгүй байх;

5.2.4.Байгууллагын хамт олны дийлэнх олонхийн саналаар дэмжигдсэн байх;

5.2.5.Орон сууцны дэмжлэгт хамрагдснаас хойш орон нутагтаа тасралтгүй 5-аас доошгүй жил ажиллах үүргийг гэрээгээр хүлээн зөвшөөрөх;

5.2.6.Аймгийн байнгын оршин суугч иргэнээр бүртгэлтэй байх.

ЗУРГАА. ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ИРҮҮЛЭХ МАТЕРИАЛ

6.1.Орон байрны дэмжлэгт хамрагдах албан хаагч нь дараах материалыг бүрдүүлж, заасан хугацаанд ирүүлнэ.

6.1.1.Байгууллагын даргын албан бичиг

6.1.2.Хамт олны хурлын тэмдэглэл

6.1.3.Төрийн албан хаагчийн анкет

6.1.4.Шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох баримт бичиг, тайлан

6.1.5.Орон байрны зээлийн мэдээллийн тодорхойлолт (Шинээр орон байр барих, худалдан авах гэрээ)

6.1.6.Оршин суугаа газрын тодорхойлолтыг e.mongolia.mn сайтаас авах

6.1.7.Олон улс, улсын хэмжээний тэмцээнд онцгой амжилт гаргасан төрийн албан хаагч болон шавь нь амжилт үзүүлсэн бол нотлох бичиг баримт

6.2.Материалын үнэн зөв байдлыг тухайн байгууллага, албан хаагч хариуцах бөгөөд бичиг баримт бүрийг баталгаажуулан гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг дарсан байна.